

1 Харилцан хамааралтай айл хөршүүдэд орчны эрүүл ахуйн талаар сурталчилах нь

Энэ бүлэгт

Эрүүл мэндийн ажилтнууд холер өвчнийг таслан зогсоов.....	8
Өөрчлөлт хийхээр хамтран ажилласан нь	9
Эрүүл мэндийн төсөл амжилттай болсны шалтгаан юу байв?	10
Орчны эрүүл ахуй хэмээх ойлголт өсч өндийсөн нь	11
Модгүй уул толгод дээвэргүй байшинтай адил	12
Асуудлын үндэс шалтгааныг олсон нь	13
Хэрхэн эрүүл мэндийн сайн хамгаалагч болох вэ?.....	14

Хуудас

Харилцан хамааралтай айл хөршүүдэд орчны эрүүл ахуйн талаар сурталчилах нь



Хүүхдийн болон гэр бүлийнхний эрүүл мэндийг сайжруулна гэдэг ямархуу ажил байдгийг хэн бүхэн мэддэг. Тэгвэл орчны эрүүл ахуйг сайжруулахад юу хийх хэрэгтэй вэ?

Орчны эрүүл мэнд гэж бидний оршин сууж байгаа газарт маань биднийг хүрээлэн байгаа зүйлс, үйл ажиллагаанаас үүдэн эрүүл мэндэд маань учирч буй нөлөөллүүдийн тухай хэлж байгаа юм. Хэрэв бидний хоол, ус, агаар маань бохирдолтой бол тэдгээрээс үүдэн өвчин тусна. Хэрэв бид агаар, ус, газраа ашиглахдаа болгоомжтой байхгүй бол бидний эргэн тойрон тэр чигээрээ өвчлөх болно. Орчныхоо эрүүл мэндийг хамгаалснаар бид өөрсдийнхөө эрүүл мэндийг хамгаалах болно.

Орчны эрүүл мэндийг сайжруулах тухай сэдэв ихэвчлэн нэг хүн биш, нэлээд хэдэн хүн, эсвэл бүр хөрш зэргэлдээ бүх хүмүүс ямар нэгэн байдлаар ижил төстэй өвчлөлд нэрвэгдэж буй нь анзаарагдаж эхлэнгүүт яригдах болдог юм. Бэрхшээл, асуудал ийнхүү нийтийнх болж эхлэмэгц хүмүүс нийтээрээ тухайн зовлонгийн өөдөөс хамтран сөрдөг. Нийтээрээ хамтран ажиллаж эхлэнгүүт хүмүүс амжилтад хүрч, өөрчлөлтийг авчирдаг юм.

Энэхүү бүлэгт бид Эквадор улсын Манглалто хотын эрүүл мэндийн төвийнхөн холер өвчний тархалтыг хэрхэн зогсоосон тухай болсон явдлыг өгүүлэх болно. Дараа нь бид хүмүүс хэрхэн хамтран ажиллаж, эрүүл мэндийн бусад бэрхшээлтэй асуудлыг шийдэж болох тухай өгүүлэх болно.

Эрүүл мэндийн ажилтнууд холер өвчнийг таслан зогсоов

Эквадор улс далайн эргийн орчимдоо жилийн зургаан сард нь хэт хуурай, зургаан сард нь дэндүү чийглэг нойтон байдаг. Ийм нөхцөлд хоол хүнс тариалах маш хэцүү. Тэнд цөөхөн зах бий. Засгийн газар нь сургууль, эмнэлэг, цэвэр бохир ус зэрэг нөхцөл хангамжийг бүрдүүлэхийн тулд өчүүхэн бага зүйлийг хийдэг байв.

1991 онд тэр нутагт холер өвчин тархах үед хүмүүс ямар ч бэлтгэлгүй байсан бөгөөд олноороо өвчилсөн юм. Өдөр болгон хүмүүс гэр бүлийнхнийхээ өвчтэй нэгнийг Манглралто гэдэг жижиг хотын эрүүл мэндийн төвд авчирч байлаа. Хүмүүс маш сул дорой, чичирсэн, халуурсан байдалтай байж, аймшигтай өвчлөлд нэрвэгдэж, усан суулгацаар өвдөж байв. Өвчтэй хүмүүсийн биеэс шингэн нь дэндүү ихээр алдагдсан байлаа.

Эрүүл мэндийн ажилтнууд өвчтөнүүдийн байдлыг хараад холер өвчин тархсаныг мэдсэн юм. Хэрэв энэ өвчнийг хурдан таслан зогсоохгүй бол нийтийг хамарсан аюул болох нь тодорхой байлаа. Холерийг үүсгэгч нь уух усанд үржиж, нэг хүнээс нөгөө хүнд хурдан тархдаг учир зөвхөн өвчтэй хүмүүсийг эмчлэх нь хангалттай бус гэдгийг эрүүл мэндийн ажилтнууд мэдэж байлаа.

Холер тархалтаас урьдчилан сэргийлэхийн тулд Манглралто хотын оршин суугч бүрт аюулгүй ус хүргэх, цэвэр жорлонтой байлгах нь амин чухал байв. Эрүүл мэндийн ажилтнууд өвчинд нэрвэгдээгүй тосгоны хүн амыг цуглуулан, тэднийг зохион байгуулалтад оруулж эхлэв. Тэд бас орон нутгийн байгууллагууд болон тэдгээрийн гадаад орнууд дахь түншүүдийг яаралтай тусламжийн мөнгө цуглуулж өгөөч гэж ятгаж чадлаа. Яаралтай тусламжийн мөнгөөр хотынхныг цэвэр усаар хангаж, жорлонг ариутгах шаардлагатай байв. Тэд энэ төслөө “Эрүүл мэндийг хүмүүст” гэж нэрлэн ойролцоох тосгонуудын эрүүл мэндийн байгууллагуудад түгээв.


Орон нутгийн эрүүл мэндийн хорооны гишүүд эрүүл мэндийн сургагч багшийг сонгож, тэр багшаар дамжуулан хүмүүст цэвэр ус, эрүүл жорлон, гар угаахын ач холбогдлыг сурталчиллаа. Гар угааж, жорлон, усны ариун цэврийг сахиснаар л нянгийн тархалтыг урьдчилан сэргийлж чадах байв. Ингэж эрүүл мэндийн ажилтнууд орон нутгийн оршин суугчдад үүрэг хүлээлгэх замаар холертой тэмцэх ажлын чухал хэсгийг хийж чадсан ба орчны эрүүл ахуйг бий болгосон юм.



Сайн зүйлийг хийхэд шаардагдах мөнгө олсон нь сайхан хэрэг байсан боловч энэ нь хангалттай байгаагүй юм. Хүмүүс холерийн тархалтаас урьдчилан сэргийлэх ажлыг хийхийн тулд өөрсдөө оролцох ёстой байсан юм.

Өөрчлөлт хийхээр хамтран ажилласан нь

Тосгоны эрүүл мэндийн сургагч багш хамгийн түрүүнд хүмүүст холер гэдэг өвчин болон бусад өвчин хэрхэн тархаж, гэдэсний суулгац бий болгож байгааг тайлбарласан юм. Тэрбээр өрх бүрт очиж, тухайн өрхийн ууж байгаа ус, ариун цэврийн өрөө болон жорлонг цэвэр болгоход нь тусалсан юм. Гэдэсний суулгац өвчнөөс нас бардаг гол шалтгаан нь шингэний дутагдал байдаг гэдгийг хүмүүст зааж өгсөн. Буцалсан усанд саахар давс хольж, шингэн нөхөх уусмал хэрхэн хийж, хүүхдийг болон шингэн дутагдсан хүмүүсийг аварч болох аргыг зааж өгөв.



Тэр сургагч багш сургууль, сүм хийд, олон нийтийн төвүүд, нийтийн хурал цуглаанууд дээр очиж холероос сэргийлэхийн тулд гараа яаж угаах, яаж аюулгүй жорлонг барьж байгуулах талаар заасан. Хэдхэн долоо хоногийн дараа холер бараг алга болсон юм.

Гэхдээ эрүүл мэндийн сургагч багш нар холерийг дахин гаргуулахгүйн тулд илүү их ажил хийх ёстой гэдгийг мэдэж байв. Орон нутгийн инженер, бусад хүмүүстэй хамтран усыг хоолойгоор урсгах систем байгуулах, тосгон болгонд хэрэглэж буй жорлонг сайжруулах, өрх бүрт ариун цэврийн дэглэм сахихад шаардлагатай усыг хүргэх ажлыг зохион байгуулахын тулд хамтран ажилласан. Тосгоныхон энэ бүх ажилд өөрсдөө оролцож, цэвэр усны систем болон жорлонг хэрхэн цэвэрлэж, арчилах талаар мэдлэгтэй болсон юм.


Амьтдын ялгадсыг тусад нь байлгаж ус руугаа оруулахгүй хамгаалахын тулд тэд мал амьтдаа хашаанд хаших болов. Өвчин тараагч шумуулууд өсөж үржихээс урьдчилан сэргийлж, худаг усныхаа амыг таглах боллоо. Эдгээр бүх ажилд тосгоны бүх хүмүүс оролцлоо. Анх энэ ажил 22 тосгонд эхэлсэн бол “Эрүүл мэндийг хүмүүст” төсөл нийтдээ 100 тосгонд хэрэгжсэн юм. Ингээд тун удахгүй бүхэл бүтэн бүс нутгаараа холерт нэрвэгдэх аюулгүй болж, бусад өвчлөлийн хэмжээ ч эрс буурсан билээ.

Эрүүл мэндийн төсөл амжилттай болсны шалтгаан юу байв?

“Эрүүл мэндийг хүмүүст” төсөл холерийг таслан зогсоож, бусад асуудлыг шийдэхэд маш амжилттай үр дүнд хүрсэн төсөл байсан юм. Энэ үр дүнд хүрэхэд дараахь зүйлс нөлөөлжээ. Үүнд, Эрүүл мэндийн ажилтнууд:

- **Хүмүүсийн гэрт нь очиж ажилласан.** “Эрүүл мэндийг хүмүүст” төслийн ажилтнууд гэрт нь очиж гэрийнхээ усан хангамжийг хэрхэн цэвэр байлгахыг хүмүүст зааж өгсөн. Энэ нь эрүүл мэндийн бусад хүндрэлтэй асуудлын талаар мэдэж авах, олон нийтийн итгэлийг хүлээхэд нь тусалсан.

- **Олон бүлгүүдийг нэг зүгт чиглүүлсэн.** Орон нутгийн байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, үндэсний болон олон улсын төрийн бус байгууллагууд, Эрүүл мэндийн яам бүгд хамтран ажилласан. Ингэснээр тэдгээр байгууллагуудад байгаа нөөц бололцоо, туршлага бүхэн хурц халдварт нийтийг хамарсан өвчнийг зогсооход чиглэж тусалсан юм. Ингэж тэд хамтран ажилласан учраас, нэг ажлыг олон байгууллага давхардуулан хийх, эсвэл бие биенийхээ эсрэг ажиллахаас нь хамгаалж чадсан байна.



- **Хүмүүсийг хамгийн чухал нөөц гэж үзсэн.** Тэд өвчин тархсан асуудалд тосгоны хүмүүсийг буруутгаагүй бөгөөд өвчнийг зогсоохын тулд зөвхөн гаднын тусламжид найдаагүй юм. Үүний оронд тэд хүмүүсийн өөрсдийнх нь туршлагыг нийтийн зорилгын төлөө авч ашигласан байна. Тэд тоглоом, хүүхэлдэйн жүжиг, дуу, яриа хэлэлцүүлэг, нийтийн лекц зэрэг үйл ажиллагааг хүмүүсийг хамтран ажиллуулах, мэдлэгээ солилцох, ур чадвараа солилцоход нь ашигласан. Эдгээр үйл ажиллагаанууд нь тосгоны хүмүүст өөртөө итгэх итгэл бий болгож, тосгоны хүмүүс өөрсдийнхөө мэдлэг оролцооны хүчээр эрүүл мэндийн хурц асуудлыг хэрхэн шийдэж чадахыг нь үзүүлж чадсан.



Орчны эрүүл ахуй хэмээх ойлголт өсч өндийсөн нь

Цаг хугацаа өнгөрөхөд эрүүл мэндийн ажилтнууд өвчин түгээгч шавжнууд нь хогийн сав, хог хаягдлын газруудад өсч үржиж байгааг анзаарсан юм. Тэд орон нутгийн иргэдийн нөхөрлөлийн хурлуудыг зохион байгуулж, гудамж талбайгаа хэрхэн цэвэрлэж, хог хаягдлын менежментээ сайжруулах талаар ярилцаж эхэлсэн.

Тосгон бүр орчны эрүүл ахуйг хамгаалагчдын бүлэг байгуулжээ. Орчны эрүүл ахуйг хамгаалагчдын бүлэг нь айлуудын хог хаягдлыг хэрхэн цуглуулж авах хуваарийг гаргав. Нэгэн инженерийн тусламжтайгаар орчны эрүүл ахуйн хамгаалагчид хог хаягдлуудыг хамгаалагдсан газарт хашиж, зохион байгуулав. Хэдэн жилийн дараа гэхэд эрүүл мэндийн хамгаалагчид хог хаягдлыг дахин боловсруулах хөтөлбөрийн талаар ярилцаж, хог хаягдлын талбайд хаях хогны хэмжээг багасгах төлөвлөгөө гаргав.

Олон улсын нэгэн агентлаг хотын хогийг цуглуулах том ачааны машин бэлэглэсний дараа тэд хог хаягдлыг ялгах ажлаа эхлүүлээ. Шил, хуванцар, цаас зэргийг дахин боловсруулахаар цуглуулж эхэлснээр тэр хаягдлын мөнгөнөөс хогны машиныхаа бензиний мөнгийг олж эхлэв.



1996 он гэхэд “Эрүүл мэндийг хүмүүст” төслийн хүрээнд хэдэн зуун жорлон байгуулж, олон усны хоолойн системийг суурилуулж, хог хаягдлын талбайн хоёр том нүхийг ухаж, хог хаягдлаас хоёр дахь түүхий эд гарган авах хөтөлбөрийг хэрэгжүүлж, нийтийн ногоон цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг эхлүүлжээ.

Гэтэл 1997 онд нэгэн аюул боллоо. Элнино гэдэг нэртэй үер бороо орж, Эквадорын эрэг орчмыг нэрвэлээ. Зургаан сарын турш тэнд хүчтэй салхи салхилж, бараг өдөр болгон бороо оров. Салхины хүчинд модод унаж, борооны усанд газар тэр чигээрээ шавар шалбааг болж, гуу жалга, хөндий тал бор өнгийн шавартай үерийн гол болон урслаа. Гол горхи үерлэж, савнаасаа халин өөр зүгт урсаж,

тосгонуудыг хаман нүүлгэж байлаа. Жорлон, усны хоолойнууд болон хэдэн жилийн турш хийсэн бүх ажлын үр дүн урсан алга болов.



Дов толгодууд хүртэл нурж “Эрүүл мэндийг хүмүүст” төслийн хүрээнд хийсэн бүхэн тэдэнтэй хамт нурлаа. Энэ бүхэн яагаад ийм болсныг ойлгохын тулд тус бүс нутгийн түүхийг судлах хэрэгтэй болов.

Модгүй уул толгод дээвэргүй байшинтай адил

Нэгэн цагт Эквадорын эргийн уул толгод нь шигүү ургасан халуун орны ширэнгэ ойгоор хучаастай байжээ. Мангров хэмээх мод тэнд олноороо ургаж, далайн эргийн давстай ус, борооны цэвэр ус холилдон түүнийг тэжээдэг байлаа. Мангров моднууд нь эргийн нутгуудыг далайн шуурганаас хамгаалж нэг ёсны хаалт болж байх ба шуурганд туугдсан загас, хясаануудын орон гэр болох нөхцөл нь болдог байжээ. Мөн хулс моднууд гол горхийн дагуу ургаж, голын эргийг усанд элэгдэж задрахаас хамгаалдаг байжээ. Бас ой модонд нь Сэйбо хэмээх аварга том мод олноороо урагж, эргийн газарт сүүдэр бий болгодог байв. Тэдгээр моднуудын гүнзгий том үндэснүүд нь ус хөрс хоёрыг хамгаалж чийг хуримтлуулдаг байлаа. Кароб моднууд уулын эгц налуу энгэрүүдэд ургаж, уулын уруу хөрс шороо өнхрөн урсахаас хамгаалж хөрсийг бэхжүүлдэг байв. Энэ бүх моднуудын навчис нь унаж, газрын хөрсөн дээр дэвсгэр болон бүрхэж, шороо сулрахаас хамгаална. Энэ сайхан ой мод, хүмүүс, буга, гөрөөс, шувуу, шавж, мөлхөгч амьтад гээд тоолж баршгүй олон амьтны орон гэр болдог байв. Хүмүүс орон гэрээ хулс модоор хийж, далдуу модны навчисаар бүрдэг байв. Тэнд агнах амьтан, түүх жимс, уух ус, жижиг тариалан эрхлэх үржил шимтэй газар хангалттай байжээ.

Гэвч сүүлийн 100 жилийн туршид тэдгээр модны ихэнхийг тайрч барилга барих, төмөр зам тавихад ашиглажээ. Японоос ирсэн нэгэн компани үлдсэн модны ихэнхийг тайрч төмөр зам тавихад ашигласан ба бас маш их хэмжээний модыг Япон руу ачуулжээ. Халуун орны мод хатуулаг чанартай учир Эквадорын мод өндөр үнээр зарагдаж байв. Мод тайрч дуусаад гадаадын компани гараад явжээ. Тэдгээрийн тавьсан төмөр зам нь эзэнгүй хоцорч, элэгдэж муудав. Цаг хугацаа өнгөрөхөд тэр зам хэнд ч хэрэггүй болж эзэнгүй хаягджээ.

Одоо Эквадорын эргийн уул толгод нь бараан бор өнгөтэй, ямар ч сүүдэр байхгүй болж. Хуурай улирал эхэлмэгц тэрхүү хуурай шороо нь агаарт битүү тоос босгоно. Борооны улиралд тэр шороо нь шавар болж, шавартай ус уулын уруу урсана. Элмино хэмээх үер бороо 1997 онд орох үед тосгоныхныг аймшигт үерээс хамгаалах зүйл огт үлдээгүй байв.




Асуудлын үндэс шалтгааныг олсон нь

Борооны ус бүхэл бүтэн тосгоныг урсган авч явахыг харсан орчны эрүүл мэндийг хамгаалагчид “Эрүүл мэндийг хүмүүст” төслийнхөө хүрээнд цаашид учрах аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд өөр бусад ажлыг ч бас хийх шаардлагатай юм байна гэдгийг олж харжээ. Цэвэр усны систем байгуулах, эрүүл ариун цэврийн орчин бүрдүүлэх нь асуудлыг шийдвэрлэх зөвхөн нэг арга ажээ.

Тосгоны хүн амын дотор тэд нэгэн шинэ үг хэллэг гаргав. “Модгүй уул бол дээвэргүй байшинтай адил” гэсэн үгийг тэд гаргажээ. Уул толгод модтой бол бороо ороход тосгоны газрыг үерт автахаас хамгаалах учир байшингийн дээвэр хүмүүсийг үерээс хамгаалдагтай тэд ийнхүү зүйрлэсэн байна. Эрүүл мэндийн ажилтнууд мод тарих, байгалийн баялаг хамгаалах ажлыг эрүүл мэндийн ажлын нэгэн адил сурталчилж хийх болжээ. Яагаад гэвэл тэд яг л нэг зорилготой ажлууд байв. Ийм ч учраас эрүүл мэндийг хамгаалагчид мод тарих төслийг хэрэгжүүлж эхэллээ.

Гэвч тосгоны зарим иргэд мод тарихыг хүсэхгүй байв. Жишээлбэл, Эдвардо хэмээх эр мод тарих төсөлд оролцохгүй гэж мэдэгдэв. “Наадах чинь дэндүү их ажил” гэж Эдвардо хэлээд, бидэнд хөлс мөнгө өгөхгүйгээр хэтэрхий их зүйл хийлгэх гээд байна гэж гомдоллов. Тэрбээр тосгоныхоо бусад хүмүүсийг ч бас ингэж ятгасаар эрүүл мэндийн хамгаалагчдын эсрэг байр суурийг олон хүнд бий болгожээ.

Эрүүл мэндийн ажилтан Глория иргэдийг цуглуулан “Гэвч яагаад” гэдэг нэртэй үйл ажиллагаа зохион байгууллаа. “Гэвч яагаад” гэдэг үйл ажиллагаанд оролцсон хүн бүр өөртөө тулгамдаад байгаа асуудлын учир шалтгааныг мэдэхийн тулд “гэвч яагаад” гэж асуух үүрэгтэй байлаа. Яагаад тэдний жорлон урсаад явчихав, яагаад цэвэр усны хоолой эвдрэв, яагаад тосгон шаварт оров зэрэг асуултуудыг асуух ёстой байв.




Гэвч яагаад гэдэг асуултыг ингэж асууснаар тосгоныхон тэдэнд тохиолдсон эрүүл мэндийн асуудал нь тухайн нутгийн байгаль орчны асуудалтай холбоотой гэдгийг ойлгосон юм. Хэлэлцүүлгийн төгсгөлд хүмүүс уулын энгэрт мод тарих нь хөрсийг хамгаалж, цаашид тэднийг хамгаална гэдгийг ойлгосон. Гэвч Эдвардо зөрүүдэлсэн хэвээр байв.



Мод тарихаа гэдэг хэтэрхий их ажил, бид модноос ямар ч ургац авахгүй, мөнгө олохгүй, бидэнд оноодор идэх хоол хэрэгтэй байна. Арван жилийн дараах мод хэрэггүй.

Хэрхэн эрүүл мэндийн сайн хамгаалагч болох вэ?

Эрүүл мэндийн төв рүү буцаж ирэхдээ Глориягийн урам хугарсан байлаа. Мод тарих нь чухал гэдгийг хүмүүс ойлгосон ч гэсэн тэд мод тарьж өгөхгүй нь гэж бодов. Тэднийг явал мод тарьж өгөх бол гэж тэр бодлоо. Яг энэ мөчид өрөөнд нь зөгий орж ирж толгой дээр нь эргэлдэв. Глория гараа саван зөгийг хөөгөөд араас нь ширтэв. Зөгий цонхоор гарч нисээд Кароб модны улаан цэцгэн дээр суулаа. Үүнээс тэр гэнэт шинэ санааг сэдэв. Маргааш өдөр нь Глория тосгоныхныг дахин цуглууллаа. Тэр өөр нэгэн асуулт асуухад Эдвардо хамгийн түрүүнд хариулав.



Та бүхэн арван жилийн дараах амьдралаа додохоосоо илүү оноодрийнхөө амьдралд шаардлагатай мөнгийг олох ёстой. Та нар бас мод тарих нь чухал гэдгийг мэдэж байгаа. Модноос ашиг олж болох ямар арга байгааг та нар мэдэж байна уу?



Бид нар мэдэж модыг тайрч унагаагаад гуалин болгоод зарж болно. Тэхдээ ингэхийн тулд бараг зуун жил хэрэгтэй болно.

Тосгоны бусад хүмүүс дахин бодож янз бүрийн санаа гаргав.



Бид модны хөвөнгөөр дэр хийгээд, зарж болох юм.

Кароб модны навч зүлгийг идэх мал өсгөж болох юм.

Далдуу модны салар, угаар сувенир хийж зарж болох юм.

Наадуул чинь бүгд сайхан санаанууд байна. Энэ бол мод тарих илүү их үндэслэл бий болгож байна. Наагад ч бас өөр нэг санаа байна. Түүнийгээ та бүхэнтэй хуваалцах гэсэн юм. Энд байгаа хүмүүс зөгийн баланс дунтай юу?

Глория хүмүүс рүү хандан: Хэрвээ бүгдээрээ зөгийнд таалагддаг цэцэгтэй мод тарих юм бол зөгий үржүүлэн зөгийн балыг нь зарж болох юм. Мод цэцэглэх хүртэл ганцхан жил хэрэгтэй шүү дээ гэв. Тосгоныхонд энэ санаа маш их таалагдав. Тэр ч байтугай Эдвардо хүртэл мод тарих ажилд оролцохыг зөвшөөрч, зөгийн бал яаж гаргадаг юм бэ гэж асууж эхэллээ.

Уулзалт тараад явах үедээ Эдвардо Глорияг зогсоож, ингэж хэлэв: Миний ач хүүгийн гэдэс нь өвдөж шингэн алдах үед бид Кароб модны хальсаар ундаа найруулж хүүдээ өгөхөд ямар ч эмнээс илүү эмчилж чадсан юм шүү. Тэгэхээр бүгдээрээ Кароб мод тарья. Тэгээд тэр модноосоо эмчилгээний ундаа гаргаж авангаа тэр ундаагаа чихэрлэг болгох зөгийн бал ч бас авч болох юм байна гэж хэллээ.

Эрүүл мэндийн төв рүүгээ буцаж ирэхдээ Глория олон шинэ санаатай болсон байлаа. Уулзалтаа хэрхэн зохион байгуулсан талаараа эргэн бодоод Глория нэг зүйлийг ойлгож авлаа. Тэрбээр тосгоныхонд юу хийхийг нь зааж болохгүй юм байна гэдгийг ойлголоо. Харин ч эрүүл мэндийн сайн хамгаалагч байхын тулд хүмүүсийг сайн сонсож, тэдэнд юу хэрэгтэй байгааг ойлгож, тэдний санаачлагыг сонсож, тэдэнд тохиолдож буй асуудлыг нүдээрээ харах ёстой юм байна гэдгийг ойлгосон.